





III бүлэг. Дэлхийн
гадарга бүрэлдэх үйл
явц.



3.1 Дэлхийн дотоод
бүтэц.


Дэлхийн гадаргын онцлог.



Дэлхийн гадаргын 71%-г ус эзэлдэг. Гэвч экватороос 2 тийш жигд биш. Хуурай газар хойд хагаст 39%, өмнөд хагаст 19%-г эзэлнэ. Дэлхийн гадарга өндрийн зөрүү ихтэй. Далайн дундаж гүн 3800 м боловч түүний ёроолын хотгор гүдгэр олон янз. Далайн хамгийн гүн хонхрууд далайн зах хавиар, өндөр уул нурууд эх газрын захаар байрласан байдаг.


Дэлхийн дотоод бүтэц үндсэн гурван хэсгээс бүтдэг.

1. Газрын давхарга
2. Манти
3. Цөм



Дэлхийн дотоод үе давхаргууд.

1. Газрын давхарга-0-40 км
 2. Дээд манти- 40-660 км
 3. Доод манти-660-2900 км
 4. Гадаад цөм- 2900-5150 км
 5. Дотоод цөм-5150-6371 км
- А. Мохорын зааг
Б. Гутенбергийн зааг



1. Газрын давхарга

(дэлхийн хамгийн гадна талд орших хатуу бүрхүүл)

1. Эх
газрын
давхрага

35-45 км

Тунамал
Боржин
Хүрмэн гэсэн
3 үетэй.

2.
Далайн
давхрага

3-5 км

Тунамал
Хүрмэн
чулуулгийн
гэсэн 2 үетэй.

2. Манти

1. Дээд манти

- 40-660 км
- Астиносфер
(шингэн)

2. Доод манти

- 660-2900 км
- Төмөр, магни, хар
тугалга ихтэй.

3. Цөм


1. Гадаад ЦӨМ



- 2900-5150 км
- Бодис шингэн байдалтай оршино.

2. Дотоод ЦӨМ

- 5150-6371 км
- Хатуу бодисоос ТОГТОНО.

Дэлхийн дотоод бүтэц





Дэлхийн дотоод бүтэцийн
схемийг гүйцээ.



Асуултанд хариулж өөрийгөө шалгана уу?

1. Дэлхийн дотоод энерги юунд нөлөөлөх вэ?

- А . Уур амьсгалыг өөрчлөгч хүч болно.
- Б. Теотоникийн үйл явц , газар хөдлөл галт уулын дэлбэрэлтийг үүсгэнэ
- В. Далайн шуурга давалгааг үүсгэнэ.

2. Литосфер буюу чулуун мандал гэж юуг хэлэх вэ?

- А. Дэлхийн гадаад хатуу бүрхүүл
- Б. Газрын гадарга ба астеносферийг хамтад нь
- В. Астеносфер хүртэлх дээд мантийн хэсэг газрын гадаргыг хамтад нь

3. Галт уул дэлбэрэх газар хөдлөх тектоник үйл ажиллагааны үүсэх бүсийг..... гэнэ.

- а. Цөм
- б. Манти
- в. Астеносфер